

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/005/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026.02.16	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
	Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a> Аудитор Д.Оюун-Эрдэнэ Утас: 88916603 Цахим хаяг: <a href="mailto:oyun-erdenede@audit.gov.mn">oyun-erdenede@audit.gov.mn</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.16 № 2/08

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор аймгийн Прокурорын газрын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд 1,824,944.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,819,026.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,762,025.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 57,000.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

6426050027

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжүүлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,024,263.0</b>	<b>68,713,913.0</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
31211	Төрийн сангийн харилцах	2,000,000.0	2,000,000.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>72,024,263.0</b>	<b>66,713,913.0</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>72,024,263.0</b>	<b>66,713,913.0</b>
35410	Бичиг хэргийн материал	3,480,900.0	3,416,900.0
35420	Аж ахуйн материал	37,631,450.0	40,258,400.0
35430	Сэлбэг хэрэгсэл	4,641,000.0	4,641,000.0
35470	Бусад хангамжийн материал	26,270,913.0	18,397,613.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,481,746,519.6</b>	<b>3,329,206,806.7</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,481,746,519.6</b>	<b>3,329,206,806.7</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,430,088,786.3</b>	<b>3,277,782,406.7</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,158,932,197.0	3,158,932,197.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,526,397.7)	(152,241,934.4)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	319,909,485.2	255,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,874,725.1)	(93,620,833.3)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,555,310.8	166,768,194.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,373,644.1)	(104,584,960.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,577,994.0	93,923,826.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,111,433.7)	(46,394,082.8)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>51,657,733.4</b>	<b>51,424,400.1</b>
39301	Програм хангамж	700,000.0	700,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(116,666.6)	(349,999.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,074,400.0	51,074,400.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,555,770,782.6</b>	<b>3,397,920,719.7</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	2,000,000.0	2,000,000.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,553,770,782.6</b>	<b>3,395,920,719.7</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,553,770,782.6</b>	<b>3,395,920,719.7</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	439,978,322.1	439,978,322.1
51101	Өмч: - төрийн	439,978,322.1	439,978,322.1
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,901,337,180.4</b>	<b>2,743,487,117.5</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,901,337,180.4	2,901,337,180.4
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	(157,850,062.9)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,455,280.1	212,455,280.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,555,770,782.6</b>	<b>3,397,920,719.7</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,688,920,330.0</b>	<b>1,855,020,850.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>252,062,730.0</b>	<b>25,772,300.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	252,062,730.0	25,772,300.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,436,857,600.0</b>	<b>1,829,248,550.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,417,357,600.0	1,819,026,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,417,357,600.0	1,819,026,200.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,500,000.0	10,222,350.0
131103	ЗГНХ, ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,500,000.0	10,222,350.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,566,595,728.9</b>	<b>1,965,991,840.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,566,595,728.9</b>	<b>1,965,991,840.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,465,631,505.2</b>	<b>1,908,991,532.4</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,043,816,989.3</b>	<b>1,469,627,958.1</b>
210101	Үндсэн цалин	594,855,459.4	891,280,354.7
210102	Нэмэгдэл	304,625,404.2	452,486,668.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,255,395.7	73,746,000.0
210104	Урамшуулал	78,080,730.0	52,114,934.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>130,366,424.1</b>	<b>185,239,060.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	89,091,317.7	126,555,559.9
210202	Тэтгэмжийн даатгал	10,481,331.5	14,888,889.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,214,265.9	7,522,918.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,115,901.9	7,254,339.0
210205	Эрүүл мэндийн даатгал	20,463,607.1	29,017,354.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,883,782.4</b>	<b>62,247,197.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,757,292.4	9,345,265.1
210302	Түлш, халаалт	43,603,560.0	45,405,360.0
210303	Цэвэр, бохир ус	5,522,930.0	7,496,572.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,232,951.5</b>	<b>46,306,182.0</b>
210401	Бичиг хэрэг	14,241,800.0	17,045,800.0
210402	Тээвэр, шатахуун	16,381,656.0	10,047,145.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,831,795.5	6,562,637.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.0	1,200,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,906,700.0	2,929,300.0
210408	Бараа материал акталсны зардал	1,671,000.0	8,521,300.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,709,400.0</b>	<b>4,167,470.0</b>
210604	Урсгал засвар	25,709,400.0	4,167,470.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,793,000.0</b>	<b>920,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,793,000.0	920,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,432,329.0</b>	<b>5,486,724.0</b>

**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,429,830.0	4,800,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	334,444.0	200,332.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	00.0
210807	Газрын төлбөр	624,055.0	486,092.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>145,396,628.9</b>	<b>134,996,940.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,100,000.0	1,400,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,024,000.0	2,164,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,272,628.9	131,432,940.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,964,223.8</b>	<b>57,000,307.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,620,000.0</b>	<b>00.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.0	00.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>96,344,223.8</b>	<b>57,000,307.8</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,344,223.8	57,000,307.8
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>122,324,601.1</u></b>	<b><u>(110,970,990.3)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.0</b>	<b>46,879,072.6</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.0	46,879,072.6
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.0</b>	<b>(46,879,072.6)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>122,324,601.1</u></b>	<b><u>(157,850,062.9)</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,438,857,600.0</u></b>	<b><u>1,832,061,810.5</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,813,260.5</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,813,260.5</b>
120009	Бусад орлого	2,000,000.0	2,813,260.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,436,857,600.0</b>	<b>1,829,248,550.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,417,357,600.0</b>	<b>1,819,026,200.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,417,357,600.0	1,819,026,200.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>19,500,000.0</b>	<b>10,222,350.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,500,000.0	10,222,350.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,439,000,300.0</u></b>	<b><u>1,832,061,810.5</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,439,000,300.0</b>	<b>1,832,061,810.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,335,893,376.3</b>	<b>1,775,061,502.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,043,816,989.3</b>	<b>1,472,441,218.6</b>
210101	Үндсэн цалин	596,673,690.1	895,547,255.4
210102	Нэмэгдэл	303,458,170.1	451,446,358.8



**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	65,604,399.1	73,332,669.6
210104	Урамшуулал	78,080,730.0	52,114,934.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>130,366,424.1</b>	<b>185,239,060.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	89,091,317.7	126,816,331.2
210202	Тэтгэмжийн даатгал	10,481,331.5	14,820,119.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,214,265.9	7,488,532.8
210204	Ажилгүйдлийн даатгал	5,115,901.9	7,222,815.8
210205	Эрүүл мэндийн даатгал	20,463,607.1	28,891,262.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,883,782.4</b>	<b>62,247,197.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,757,292.4	9,345,265.1
210302	Түлш, халаалт	43,603,560.0	45,405,360.0
210303	Цэвэр, бохир ус	5,522,930.0	7,496,572.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,331,451.5</b>	<b>39,088,382.0</b>
210401	Бичиг хэрэг	13,406,800.0	16,871,800.0
210402	Тээвэр, шатахуун	14,991,656.0	10,047,145.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,896,295.5	6,562,637.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,836,700.0	4,406,800.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.0</b>	<b>648,000.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.0	648,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,323,400.0</b>	<b>4,926,920.0</b>
210604	Урсгал засвар	14,323,400.0	4,926,920.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,793,000.0</b>	<b>920,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,793,000.0	920,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,454,329.0</b>	<b>5,986,724.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,451,830.0	5,300,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	334,444.0	200,332.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	00.0
210807	Газрын төлбөр	624,055.0	486,092.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,924,000.0</b>	<b>3,564,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,850,000.0	1,400,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,074,000.0	2,164,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>103,106,923.8</b>	<b>57,000,307.8</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>2,142,700.0</b>	<b>00.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,142,700.0	00.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,620,000.0</b>	<b>00.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.0	00.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>96,344,223.8</b>	<b>57,000,307.8</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,344,223.8	57,000,307.8
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(142,700.0)</u></b>	<b><u>00.0</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(142,700.0)</b>	<b>00.0</b>

**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	2,142,700.0	2,000,000.0
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	2,000,000.0	2,000,000.0

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,779,012,579.4	00.0	3,431,446,181.6
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,779,012,579.4	00.0	3,431,446,181.6
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	197,066,635.5	00.0	197,066,635.5
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,901,337,180.4	00.0	3,553,770,782.6
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,901,337,180.4	00.0	3,553,770,782.6
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,901,337,180.4	00.0	3,553,770,782.6
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	(157,850,062.9)	00.0	(157,850,062.9)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,978,322.1	212,455,280.1	2,743,487,117.5	00.0	3,395,920,719.7

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,824,944,200.0</b>	<b>1,762,025,892.2</b>	<b>62,918,307.8</b>	<b>96.6</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,824,944,200.0	1,762,025,892.2	62,918,307.8	96.6
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,824,944,200.0</b>	<b>1,762,025,892.2</b>	<b>62,918,307.8</b>	<b>96.6</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>1,699,407,600.0</b>	<b>1,647,144,669.1</b>	<b>52,262,930.9</b>	<b>96.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,502,965,600.0</b>	<b>1,462,750,927.1</b>	<b>40,214,672.9</b>	<b>97.3</b>
Үндсэн цалин	798,270,200.0	892,733,994.9	(94,463,794.9)	111.8
Нэмэгдэл	477,852,200.0	444,569,327.8	33,282,872.2	93.0
Унаа хоолны хөнгөлөлт	96,895,300.0	73,332,669.6	23,562,630.4	75.7
Урамшуулал	129,947,900.0	52,114,934.8	77,832,965.2	40.1
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>196,442,000.0</b>	<b>184,393,742.0</b>	<b>12,048,258.0</b>	<b>93.9</b>
Тэтгэврийн даатгал	133,596,700.0	125,971,012.3	7,625,687.7	94.3
Тэтгэмжийн даатгал	15,717,200.0	14,820,119.0	897,081.0	94.3
ҮОМШӨ-ний даатгал	7,857,900.0	7,488,532.8	369,367.2	95.3
Ажилгүйдлийн даатгал	7,854,100.0	7,222,815.8	631,284.2	92.0

**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Эрүүл мэндийн даатгал	31,416,100.0	28,891,262.1	2,524,837.9	92.0
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>119,618,600.0</b>	<b>114,881,223.1</b>	<b>4,737,376.9</b>	<b>96.0</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,088,900.0</b>	<b>62,247,197.1</b>	<b>841,702.9</b>	<b>98.7</b>
Гэрэл, цахилгаан	8,067,600.0	9,345,265.1	(1,277,665.1)	115.8
Түлш, халаалт	49,511,000.0	45,405,360.0	4,105,640.0	91.7
Цэвэр, бохир ус	5,510,300.0	7,496,572.0	(1,986,272.0)	136.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,977,500.0</b>	<b>39,088,382.0</b>	<b>889,118.0</b>	<b>97.8</b>
Бичиг хэрэг	13,980,700.0	16,871,800.0	(2,891,100.0)	120.7
Тээвэр, шатахуун	9,053,400.0	10,047,145.0	(993,745.0)	111.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,557,800.0	6,562,637.0	1,995,163.0	76.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	798,900.0	1,200,000.0	(401,100.0)	150.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,586,700.0	4,406,800.0	3,179,900.0	58.1
<b>Нормативт зардал</b>	<b>648,000.0</b>	<b>648,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	648,000.0	648,000.0	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,929,900.0</b>	<b>4,926,920.0</b>	<b>2,980.0</b>	<b>99.9</b>
Урсгал засвар	4,929,900.0	4,926,920.0	2,980.0	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,320,000.0</b>	<b>920,000.0</b>	<b>1,400,000.0</b>	<b>39.7</b>
Дотоод албан томилолт	2,320,000.0	920,000.0	1,400,000.0	39.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,490,300.0</b>	<b>5,486,724.0</b>	<b>1,003,576.0</b>	<b>84.5</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,577,600.0	4,800,300.0	777,300.0	86.1
Тээврийн хэрэгслийн татвар	234,500.0	200,332.0	34,168.0	85.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,700.0	-	54,700.0	-
Газрын төлбөр	623,500.0	486,092.0	137,408.0	78.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,164,000.00</b>	<b>1,564,000.00</b>	<b>600,000.00</b>	<b>72.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,400,000.00	600,000.00	70.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,000.00	164,000.00	0	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,918,000.0</b>	<b>00.0</b>	<b>5,918,000.0</b>	<b>0.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,918,000.0</b>	<b>-</b>	<b>5,918,000.0</b>	<b>-</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,918,000.0	-	5,918,000.0	-
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,824,944,200.0</b>	<b>1,762,025,892.2</b>	<b>62,918,307.8</b>	<b>96.6</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>2,000,000.0</b>		<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>2,000,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		

**Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Төсвийн байгууллага	1	1		
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28</b>	<b>26</b>	<b>2</b>	<b>92.9</b>
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	20	18	2	90.0
Үйлчлэх ажилтан	7	7	0	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28</b>	<b>26</b>	<b>2</b>	<b>92.9</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	0	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12	11	1	91.7
Ажлын албаны албан хаагч (АА)	4	3	1	75.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Тайлант он	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>10,222,349.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>10,222,349.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>10,222,349.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>6,877,031.06</b>
210102	Нэмэгдэл		6,877,031.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>845,318.92</b>
210201	Тэтгэвэрийн даатгал		845,318.92
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>500,000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		500,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>2,000,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>10,222,349.98</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>10,222,349.98</b>
131104	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,222,349.98
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>0.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч Монгол улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллага юм.

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2025 онд дараах 4 зорилтын хүрээнд нийт 35 ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх
2. Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах
3. Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох
4. Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөж эхэлсэн байна.

- МУЕПГ-ын хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Прокурорын байгууллагын төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчийн цалинг шинэчлэн батлах тухай" А/01 дугаар тушаалаар цалин хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант хугацааны шилэн дансны мэдээлэлд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар баталсан "Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157,850.1 мянган төгрөг буюу 4.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,000.0	2,000.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	72,024.3	66,723.9	(5,310.4)
Үндсэн хөрөнгө	3,788,749.4	3,726,398.6	(62,350.8)
Хуримтлагдсан элэгдэл	(307,002.9)	(397,191.8)	(90,188.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,555,770.8</b>	<b>3,397,920.7</b>	<b>(157,850.1)</b>
Өр төлбөр	2,000.0	2,000.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	3,555,770.8	3,397,920.7	(157,850.1)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн</b>	<b>3,555,770.8</b>	<b>3,397,920.7</b>	<b>(157,850.1)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг байгаа нь барьцааны дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,713.9 мянган төгрөг болж өмнөх оноос 5,310.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 38,023.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Баянхонгор аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурорын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/05 дугаар тушаалаар бусад хангамжийн материалаас 8,521.3 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хасч, үйл ажиллагаандаа 34,812.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,726,398.6 мянган төгрөг болж 62,350.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 221 дугаар тогтоол, МУЕП-ын 2025 оны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” А/84 дүгээр тушаалаар 64,909.5 мянган төгрөгийн үнэтэй автомашиныг шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 490 дугаар тогтоол, МУЕП-ын 2025 оны “Хөрөнгийг бүртгэлээс хасах тухай” А/157 дугаар тушаалаар 12,213.6 мянган төгрөгийн өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталж,

данснаас хассан, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай” 468 дугаар тогтоол, МУЕП-ын 2025 оны “Дахин үнэлсэн хөрөнгийг бүртгэх тухай” А/156 дугаар тушаалаар элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 10,999.9 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлж 5,886.0 мянган төгрөгөөр орлогод авсан бүртгэсэн байна.

МУЕПГ-аас доорох хөрөнгүүдийг хүлээн авч орлогод авсан байна.

№	Үндсэн хөрөнгийн нэр	Н.Б.Үнэ	Тоо	Дүн	Шийдвэр
1	Компьютер Dell OptiPlex 7010 Dell 24 inch monitor	3,165,800.0	2	6,331,600.0	МУЕП-ын ХЭГ-ыг даргын 2025 оны А/11 дүээр тушаал
2	Тог баригч -APC Easy UPS 800Va	342,000.0	2	684,000.0	
3	3 үйлдэлт оффис загварын принтер Bizhub 306i	8,642,900.0	1	8,642,900.0	МУЕП-ын 2025 оны А/108 дугаар тушаал
4	Серверийн тог баригч Hikvision 3000VA/1800W UPS DS-UPS3000	720,000.0	1	720,000.0	
Нийт дүн			6	16,378,500.0	

Тайлант оны өглөгийн үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг ба энэ нь барьцаа хохирлын дансны өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,397,920.7 мянган төгрөг болж мянган төгрөг болж 157,850.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн программыг 2011 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд санхүүгийн бүртгэл тайланд 700.0 мянган төгрөгийн өртөгтэй, 350.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, ашиглалтын байдал хэвийн. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд программын шинэчлэлийн төлбөрт 55.0 мянган төгрөг урсгал зардлын төсвөөс зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,992,300.0 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 897.9 мянган төгрөгөөр бууруулж 1,991,402.1 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

Батлагдсан төсвийг МУЕП-ын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/176 дугаар тушаалаар 166,457.9 мянган төгрөгөөр бууруулан 1,824,944.2 мянган төгрөг болгон тодотгон баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,824,944.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,819,026.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,762,025.9 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь 2025 онд 2 орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 52,262.9 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт (хувь)
1	70703	1,824,944.2	1,762,025.9	62,918.6	96.6
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,813,448.6	1,757,225.6	56,223.0	96.9
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	5,918.0	0.0	5,918.0	0.0
1.3	82315 Байцаан шийтгэх ажиллагаа	5,577.6	4,800.3	777.3	86.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тайлант онд тус байгууллагын нэр дээр нийт 15,309 м2 талбайтай 4 газар эзэмших эрх байсан. Үүнээс 2400 м2 талбай бүхий 2 газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлгүй, тус 2 газрыг Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аймгийн Прокурорын газрын эзэмшил газрыг шилжүүлэх тухай” 10/80 дугаар тогтоолоор "RMB" ХХК-д шилжүүлсэн байна.

МУЕП-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/192 дугаар тушаалаар Прокурорын байгууллагын 2022-2027 онд хэрэгжүүлэх урт хугацааны “Прокурор, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийн 4.1.1 дэх “прокурор, ажилтанд зориулж орон сууцны жишиг хотхон, хорооллыг барьж байгуулах, зуслангийн газар эзэмших, ашиглах, өмчлөхөд дэмжин, газар, дэд бүтцийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллага, бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах” гэсэн заалт, МУЕП-ын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан УЕПГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 2 -ын 8 дахь заалт “Баянхонгор, Орхон аймгийн прокурорын газрын прокурор, ажилчдын орон сууц барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ хийх, барилга угсралтын ажлыг эхлүүлэх” гэсэн ажлын хүрээнд УЕП-ын туслах прокурор, хэрэг эрхлэх газрын даргад 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр №Ц-1/778 тоот дугаартай албан бичиг болон холбогдох материалыг хүргүүлж, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 1/2280 тоот албан бичгээр ГХБХБГ-т хүсэлт гаргаж дээрх 2 газрыг шилжүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Прокурорын газар, "RMB" ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр "Баянхонгор аймгийн Прокурорын газрын ажилчдын орон сууцны барилга угсралтын ажил гүйцэтгэх" №2025/01 дугаартай гэрээг байгуулж 2026 онд ашиглалтад хүлээлгэн өгөх 1 дүгээр блок байрнаас 8 ажилтан, 2027 онд ашиглалтад хүлээлгэн өгөх 2 дугаар блок байрнаас 8 ажилтанд, нийт 16 албан хаагчид 1000 - 1100 мкв талбайг, 1 мкв-ын үнэ 2,100.0 мянган төгрөг байхаар тохиролцож гэрээний үнэнд өөрчлөлт оруулахгүй байх хатуу нөхцөлтэйгөөр гэрээг байгуулан газраа шилжүүлсэн байна.

Санхүүгийн бүртгэл тайланд бүртгэлгүй, бусдад шилжүүлсэн 2 газрыг аймгийн Прокурорын газраас УЕП-ын туслах прокурор, хэрэг эрхлэх газрын даргад 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн №Ц-1/349 тоот албан бичгээр холбогдох материалыг хүргүүлж, санхүүгийн тайланд тусгах зөвшөөрөл хүссэн боловч албан ёсны хариу ирээгүй тул НББ-д бүртгээгүй байна.

### **Бүтэц орон тооны гүйцэтгэл**

Байгууллагын бүтэц орон тоог МУЕП-ын 2019 оны А/28 тоот тушаалаар батлан, 2020, 2021, 2024 онуудад бүтэц орон тоог өөрчлөн, нэмэгдүүлсэн байна. Тайлант онд нийт 28 алба хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Үүнээс, прокурорын 1 орон тоо дутуу, прокурорын туслах 1 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй, удирдах албан тушаалд-1, гүйцэтгэх албан тушаалд -14, үйлчилгээний албан тушаалд -11 ажилтан ажилласан байна.

Ажилтныг томилох, чөлөөлөхдөө УЕПГ-ын тушаал, шийдвэрийг үндэслэдэг бөгөөд 2025 онд бүтэц орон тоог өөрчлөхтэй холбоотой ямар нэгэн шийдвэр, чиглэл ирээгүй тул орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

### **Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал**

МУЕП-ын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/768 дугаар тушаалаар нэг ажилтанд өдрийн 1.0 мянган төгрөгөөр унааны хөнгөлөлт, 12.0 мянган төгрөгөөр хоолны хөнгөлөлт тооцож олгодог байна.

Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 96,895.3 мянган төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр унааны хөнгөлөлтөд 5,292.7 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтөд 68,040.0 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал**

Тус зардалтай холбоотойгоор 2025 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 66 дугаар захирамжаар "Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн" зохион байгуулахтай холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн дансаар 2,000.0 мянган төгрөг төлөвлөгдөн, зарцуулагдсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 10 хувиар тооцон 7,722.3 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 66 дугаар захирамжаар “хуулийн байгууллагуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөн”-ий санхүүжилт 2,000.0 мянган төгрөг, шагналын 500.0 мянган төгрөг, нийт 10,222.3 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 49,511.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 8,067.6 мянга, цэвэр бохир усны зардалд 5,510.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 9,053.4 мянган төгрөг батлагдаж “RMB” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Шунхлай трейдинг” ХХК-тай шатахууны гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн №Ц-1/22 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,824,944.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,249.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 11,862.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 98.7 хувь зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 22 гүйлгээний 1,914,910.7 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл бүрэн гүйцэт, бусад бүх мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажиллсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэсэн ба аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн анхаарах асуудлын дагуу Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-дүгээр хавсралтаар батлагдсан шатахуун зарцуулалтын нормативын хэмжээг мөрдөж ажилласан эсэхийг шалгахад тус тушаалыг үндэслэн МУЕП-ын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “Журам батлах тухай” А/70 дугаар тушаал, 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/124 дүгээр тушаалын дагуу түлш, шатахууны зарцуулалтад тогтоосон нормативыг мөрдөж, жолоочийн тооцооны хуудсыг автомашин тус бүрээр, холбогдох ажлын тайлан,

автомашины захиалгын хуудас, орлого зарлагын баримт бүрээр бүрдүүлэн, нийт 10,047.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн прокурорын байгууллагын ажилчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц олгох гэрээний биелэлтийн хэрэгжилтийн талаар анхаарч авч үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил илэрсэн тул зөвлөмж хүргүүлэв.

Тус илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинд нөлөө үзүүлэхгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 5.1 Зөвлөмж

5.1.1 Баянхонгор аймгийн Прокурорын газрын эзэмших эрхтэй, санхүүгийн тайланд бүртгэлгүй, нийт 2400 м2 бүхий 2 газраа ТЕЗ-ийн зөвшөөрлөөр ажилчдад хөнгөлөлттэй үнээр орон сууц олгох нөхцөлтэйгөөр хувийн хуулийн этгээдэд шилжүүлэх бартерийн гэрээг байгуулсан байна. Тус үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын нэгдүгээр хавсралтын 8.2, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 127-н б) "Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувийн хуулийн этгээдтэй байгуулсан бартерийн гэрээ амжилттай хэрэгжсэн нөхцөлд үр дүнг тухайн тайлант оны санхүүгийн тайланд бүрэн тусгах.

Зөвлөмжийн биелэлтийг, нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2027 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн Прокурорын газрын эзэмших эрхтэй, санхүүгийн тайланд бүртгэлгүй, нийт 2400 м2 бүхий 2 газраа ТЕЗ-ийн зөвшөөрлөөр ажилчдад хөнгөлөлттэй үнээр орон сууц олгох нөхцөлтэйгөөр хувийн хуулийн этгээдэд шилжүүлэх бартерийн гэрээг байгуулсан байна. Тус үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын нэгдүгээр хавсралтын 8.2, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 127-н б) "Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.	1	0	-	-	-	-	1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0</b>

-----oO-----